



Урилга No1: “УННМ МоМо төслийг дүгнэх, дараагийн шатанд хүлээлгэн өгөх” сэдэвт Олон Улсын Хурал

ХБНГУ-ын Боловсрол, Судалганы Яамны санхүүжилтээр хэрэгжиж буй Монгол-Германы хамтарсан “Төв Азийн Усны Нөөцийн Нэгдсэн Менежмент: Загвар бүс нутаг Монгол (УННМ-МоМо)” төслийн 3 дугаар үе шат нь олон улсын хамтын ажиллагаа, эрдэм шинжилгээ, судалгаа, техник технологи, инновацийг нэвтрүүлсэн, боловсон хүчний чадавхийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсээр ирсэн 12 жилийн төгсгөлд буюу 2018 онд дуусгавар болж байгаа юм.

“УННМ МоМо төслийг дүгнэх, дараагийн шатанд хүлээлгэн өгөх” сэдэвт Олон улсын хурал Улаанбаатар хотноо 2018 оны 05 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд зохион байгуулагдах гэж байна.

Энэхүү олон улсын хурлыг зохион байгуулах нэг зорилго бол МоМо төслийн багийн хамт олон, түүний хамтрагч талуудын хамтын ажиллагааны оролцоотойгоор төслийн гурван үе шатны хугацаанд хүрсэн үр дүн, ололт амжилтын талаар дүгнэн хэлэлцэх, “мэдлэг туршлагаа” хуваалцах зорилтын хүрээнд хурлын гол асуудлууд хэлэлцүүлэгдэх болно. Хурлын удаах зорилго нь төслөөс гарсан үр дүн, инноваци, ноу-хауг Монгол улс цаашлаад Төв Азийн орнуудын хэмжээнд НҮБ-аас гаргасан “Эх дэлхийгээ шинэчилье: 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөр”-ийн дор дэвшүүлсэн тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулан түгээн дэлгэрүүлэх, нэвтрүүлэхэд цаашид хамтран ажиллах боломж, төслийн саналуудыг танилцуулах юм.

Иймд усны салбарт хамаарах усны мэргэжилтнүүд, бодлого гаргагчид, эрдэмтэн судлаачид, судлаач оюутнууд та бүхнийг **УННМ МоМо төслийн үр дүн, ололт амжилтын талаар хамтран дүгнэх**, эрдэм шинжилгээ, судалгааны сүүлийн үеийн мэдээ баримт, үр дүн, бүтээгдэхүүнээ танилцуулах, Монгол орны болоод Төв Азийн хэмжээнд УННМ-ийн ирээдүйн чиг хандлагыг хэлэлцэх энэхүү олон улсын хуралд урьж байна.

Та бүхнээс хурал зохион байгуулагдах **цаг хугацааг тэмдэглэхийг** хүсэхийн сацуу бидний зохион байгуулж буй хуралд идэвхитэй оролцох, хамтран ажиллахыг хүсэж байгааг энэхүү урилгаар уламжилж байна. Хурал болох газрын байршил, илтгэлийн хураангуйг ирүүлэх хугацаа болоод дэд хуралдаануудын талаархи дэлгэрэнгүй мэдээллийг ойрын хугацаанд илгээх болно. Хурлын талаархи цаашдын мэдээ, мэдээллийг хурлын цахим хуудас <http://www.iwrm-momo.de/IWRM-conference> -аар хүлээн авах, хурал зохион байгуулагчидтай saulyequl.avlyush@ufz.de, martin.pfeiffer@ufz.de имейлээр холбогдох боломжтой.

